

“МОНГОЛ ХЭЛНИЙ ИХ ТАЙЛБАР ТОЛЬ” ЗОХИОХ АРГА ЗҮЙ

I

- 1.0 Монгол үгийг академич Ц.Дамдинсүрэнгийн боловсруулсан шинэ үсгийн дүрэм “Монгол үсгийн дүрмийн толь” /Уб., 1983/-ийг баримтлан бичнэ. Харин хуучин бичгийн хэлнээс орчин цагийн монгол хэлэнд орсон үгийг хуучин бичгийн нь хэлбэрийг харгалзана.

ЭДҮГЭЭ ^{ᠡᠳᠦᠭᠡᠭᠡ} Одоо, энэ мөчид: **эдүгээ үед** (одоо болж байгаа үе)

ИРЭЭДҮЙ ^{ᠢᠷᠡᠭᠡᠳᠦᠢ} Одоо цагаас хойш үед тохиох цаг хугацаа, хожим, хойшид; ирээгүй цаг: **ирээдүйн ажил** (хойшдын ажил), **ирээдүйн хувь заяа** (айсуй цаг үед тохиох учрал), **ойрын ирээдүй** (удахгүй ирэх цаг, ойрын үе), ...

- 1.1 Гадаад хэлнээс орсон үгсийг гол төлөв шинэ үсгийн дүрмээр хэрхэн бичиж ирсэн уламжлалыг нь баримтлан тольд толгой үг болгон оруулах бөгөөд харин гадаад үгийн өргөлтийг нь тэмдэглэхгүй.

АРМИ ^{ᠠᠷᠮᠢ} Улсын зэвсэгт хүчний цогц, бүрэлдэхүүн: **ардын арми** (улсын зэвсэгт хүчин), **байнгын арми** (байнгын зэвсэгт хүчин), **түүх улаан арми** (эв хамт үзэл суртлыг хамгаалах зэвсэгт хүчин).

НАЙМАА ^{ᠨᠠᠶᠢᠮᠠᠠ} Худалдаа, арилжааны ажил: **наймаа алдах** (зарлагаа нөхөж чадахгүй алдагдалд орох), **наймаа буцах** (а. Худалдсан зүйлээ эргүүлж авах; б. Урьд тохирсноо хүчингүй болгох), **наймаа таарах** (худалдаа, арилжаа хийхдээ үнийн тал дээр санал нийлэх).

- 1.2 Гадаад хэлнээс орсон үгийн уйгаржин монгол үсгээр тэмдэглэгдсэн хэлбэр нь монголчуудын уламжлалт дуудлагаас өөр байвал дуудаж заншсан хэлбэрийг нь тольд тусган оруулна.

МАХРААЗ ^{ᠮᠠᠬᠢᠷᠠᠭᠠᠰ} Махранз.

МАХРАНЗ ^{ᠮᠠᠬᠢᠷᠠᠨᠵ} *шашин* Шашны ёсны үйл сахигч их хаан.

- 1.2.1 Хуучин бичгийн хэл, шинэ бичгийн хэлний аль алинд нь байдаг авч, мэргэжлийн бус хүнд гадаад хэлний үг гэдэг нь мэдэгдэхгүй болсон үгийг зөв бичих зүйн толиудад хэрхэн тэмдэглэж ирсэн уламжлалыг баримтлан тольд толгой үг болгон оруулна.

ДААВУУ ^{ᠳᠠᠠᠪᠠᠭᠤ} Нэхмэлийн суурь машин болон гар аргаар тууш хөндлөн сүлжиж бэлтгэдэг нэгэн зүйл нэхмэл бөс: **ёрог даавуу** (а. Сулхан нэхээстэй даавуу; б. Хуучирч өгөрсөн даавуу), **гэрийн даавуу** (монгол гэрийн гадуур бүрэх бүрээс даавуу), ...

ЦОНХ ^{ᠴᠣᠨᠬ} Байшин барилга, машин тэрэг зэрэгт гэрэл, агаар оруулах гэгээвч.

- 1.3 Хэдийгээр орчин цагийн монгол хэлэнд адил бичлэгтэй боловч, өөр утгатай үгийг тус тусад нь толгой үг болгон ром тоогоор дугаарлан холбогдох өгүүллийг нь дагалдуулан бичнэ.

ОРОЙ I ^{ᠣᠷᠣᠢ I} Өглөө гэдгийн эсрэг утга, өдрийн төгсгөл, үдэш: **орой болох** (нар шингэж үдэш болох), ...

ОРОЙ II ^{ᠣᠷᠣᠢ II} Юмны хамгийн дээд этгээд, дээд хувь: **хавтгай орой** (юмны дээд хэсэг хавтгай хэлбэртэй байгаа нь), ...

ОРОЙ III ^{ᠣᠷᠣᠢ III} Ам дөрвөлжин бөсийг дөрөв хуваасны нэг: **орой торго** (торгыг дөрөв хуваасны нэг), **орой хоргой** (хоргойг дөрөв хуваасны нэг хувь), ...

ОРОЙ IV ^{ᠣᠷᠣᠢ} хуучирсан Дуулганы дээр хадсан дүгрэг төмөр.

- 1.3.1 Орчин цагийн монгол ярианы хэлэнд адилавартар дуудлагатай боловч зөв бичих зүйд өргөн хэрэглэгддэг бэлгэ тэмдгийн зарчмыг баримтлан ялгаатай бичигддэг үгийг тус тусад нь толгой үг болгон оруулна.

БИЛИГ I ^{ᠪᠢᠯᠢᠭᠢ} Оюун ухаан төрөлхийн хурц, авьяас.

БИЛИГ II: ^{ᠪᠢᠯᠢᠭᠢ} **билгийн улирал** *зурхай* (сарны явдлыг баримталж цаг улирлыг тогтоох зурхайн ёс), ...

БЭЛГЭ I ^{ᠪᠡᠯᠭᠡ} Шинж, тэмдэг, совин ёр, илбэ: **бэлгэ ёр** *хориоо* (шинж тэмдэг), ...

БЭЛГЭ II ^{ᠪᠡᠯᠭᠡ} **1.** Хүн, амьтны им эрхтэн: **бэлгэ эрхтэн** (хүн, амьтны хүйс ялгах эрхтэн), ... **эм бэлгэ** (эм хүн, амьтны им эрхтэн), **эр бэлгэ** (эр хүн, амьтны им эрхтэн); **2.** *хуучирсан* Харуул манаа зэрэгт хэрэглэдэг тэмдэг шошго.

БЭЛГЭ III: ^{ᠪᠡᠯᠭᠡ} **бэлгэ тэмдэг** (дөчин нэгэн оронтой тооны нэр), **их бэлгэ тэмдэг** (дөчин хоёр оронтой тооны нэр).

БЭЛЭГ I ^{ᠪᠡᠯᠡᠭ} Талархаж өгөх юм.

БЭЛЭГ II ^{ᠪᠡᠯᠡᠭ} *тоглоом* Хөлөг дээр дөрвөн чулуу тавьж, ээлжлэн нүүж, гурван гэр барьдаг тоглоом.

- 1.4 Орчин цагийн монгол утга зохиолын хэлэнд хэрэглэгддэг авч тэр нь найруулгын учир холбогдолтой бол түүнийг толгой үг болгоод түгээмэл хэрэглэгддэг хэлбэрийг ард нь тавин холбогдох өгүүллийг нь дагалдуулна.

НАХИРАХ ^{ᠨᠠᠬᠢᠷᠠᠬ} Нахилзах.

НАХИЛЗАХ ^{ᠨᠠᠬᠢᠯᠵᠠᠬ} Нахигар юмны дахин дахин хөдлөх: **уурганы үзүүр нахилзах** (уурганы үзүүр байн байн дохилзох).

- 1.4.1 Нэг үгийн өөр өөр хувилбарыг тус тус толгой үг болгоод тэдгээрийн дотроос хамгийн түгээмэл хэрэглэгддэг үгэнд тайлбар, холбогдох жишээг дагалдуулна.

МИЧ (ИН) ^{ᠮᠢᠴ} *амьтан* Бич.

БИЧ(ИН) ^{ᠪᠢᠴ} *амьтан* Дөрвөн мөчний эрхий хуруу нь бусад хуруунаасаа салангид учир атгаж авирахдаа сурамгай, урт гар, сүүл нарийн, гуя туранхай бие бүхий, хүнтэй адил шүдтэй амьтан: **алтан бич** *амьтан* (урт сүүлтэй, алтан утас мэт гялалзсан шар үстэй нэг зүйл бич).

ГУЙЛАНЧИН ^{ᠭᠦᠢᠯᠠᠨᠴᠢᠨ} Гуйлгачин.

ГУЙЛГАЧИН ^{ᠭᠦᠢᠯᠭᠠᠴᠢᠨ} Гуйлга гуйж амьдардаг хоосон ядуу хүн: **гуйлгачин байдал** (хоосон ядуу байдал), **гуйлгачин болох** (юу ч үгүй хоосон болох), **гуйлгачин түүлэгчин** *хориоо* (хоосон ядуу хүн).

- 1.4.2 Голдуу нэр томъёоны чанартай үг тухайн гадаад хэлээрээ бас монгол үгээр хэрэглэгдэх нь түгээмэл байдаг авч бид уул гадаад үгийг толгой үг болгоод бас монгол орчуулгыг нь ард нь хадна. Гэхдээ монгол орчуулга нь нэг үгээр бүтсэн байвал тухайн үгийг нь толгой үг болгоод, хэрэв нийлмэл үгээр бүтсэн байвал аль гол утга илэрхийлж байгаа үгийг нь тухайн толгой үгийн дотор хамааруулан нийлмэл үгээр нь оруулаад тайлбар өгүүллийг нь дагалдуулна.

ФЕН ^{ᠮᠡᠨ} 1. Хөгжөөн дэмжигч 2. Шүтэн бишрэгч

ХӨГЖӨӨХ ^{ᠬᠥᠭᠵᠡᠬᠡ} ...**хөгжөөн дэмжигч** (өөрийн үзэл бодол, сонирхол, таашаалд нийцсэн аливаа хүн, спортын төрөл, урлагийн урсгал чиглэл зэргийг чин сэтгэлээсээ урамшуулж хөхиүлэх), ...

ШҮТЭХ ^{ᠰᠦᠲᠡᠬᠡ} ...**шүтэн бишрэгч** (а. Ихэд хүндлэн бишрэгч; б. Дуучин, жүжигчин, улс төрийн зүтгэлтэн зэрэг нэр хүндтэй олны танил хүмүүсийг хүндэтгэн хайрлаж, даган дуурайх хүн).

- 1.4.3 Өгүүлбэрийн дотор дангаараа биш гагцхүү холбогдох үгтэйгээ нийлж байж хэрэглээнд ордог үгийг толгой үг болгон ард нь давхар цэг тавин түүний хойно уул холбоо үгийг бичиж утгыг нь тайлбарлан холбогдох жишээний хамт бичнэ.

ЭСЭН: ^{ᠡᠰᠡᠨ} **эсэн мэнд хориоо** (эрүүл саруул), **энх эсэн хориоо** (өвчин зовлонгүй).

НАЧИР: ^{ᠨᠠᠴᠢᠷ} **учир начир хориоо** (а. Хэрэг явдлын шалтгаан; б. Эмх цэгц), **учир начир нь олодох** (тухайн хэргийн ээдрээ тайлагдаж, тодорхой болох).

- 1.5 Өргөн хэрэглэгддэг хоршоо үгийн заримынх нь байр нэлээд тогтвортой, заримынх нь байр тогтворгүй хоёр янз байдаг. Тогтвортой хоршоо үгийн бүрэлдэхүүнд орсон эхний үгийг толгой үгийн бүрэлдэхүүнд оруулан утгыг нь тайлбарлаж жишээг хадна.

АХ I ^{ᠠᠬ} ... **ах дүү хориоо** (а. Нэг эхээс төрсөн хүүхдүүд; б. Төрөл садан хүмүүс; в. Насаар зөрүү хүмүүс).

ӨНДӨР ^{ᠥᠨᠳᠦᠷ} ... **өндөр нам хориоо** (юмны босоо уртын хэмжээ).

Байр нь тогтворгүй хоршоо үгийн бүрэлдэхүүнд орсон нэгжүүдийн байр сэлгэх нь найруулга, утга зүйн учир холбогдолтой тул тэдгээрийг холбогдох холбогдох толгой үгийн дотор оруулж дагалдах өгүүлэл, жишээг хавсаргана.

ЗОВЛОН ^{ᠵᠣᠪᠯᠠᠨ} ... **зовлон жаргал хориоо** (хэцүү бэрх чанар, амьдралын сайн сайхан).

ЖАРГАЛ I ^{ᠵᠠᠷᠭᠠᠯ} ... **жаргал зовлон хориоо** (амьдралын сайн муу юмс үзэгдэл, амар амгалан гай зовлон).

Мөн нөхцөл үйлийн болон үйлт нэрийн хэлбэр аван бүтсэн хоршоо үг нь үгийн сангийн тодорхой утга илэрхийлж байгаа эхний үгийг нь толгой үг болгоод давхар цэг тавьсны дараа хоршоо үгийг нь бичиж утгыг нь тайлбарлав.

ЧАДАН: ^{ᠴᠠᠳᠠᠨ} **чадан ядан хориоо** (арай чамай, дөнгөн данган), **чадан ядан бичих** (мэдлэг боловсрол дутаж дөнгөн данган бичих), ...

ЯДАН: ^{ᠶᠠᠳᠠᠨ} **чадан ядан хориоо** (арай чамай, дөнгөн данган), **чадан ядан бичих** (мэдлэг боловсрол дутаж дөнгөн данган бичих), **чадан ядан гүйх** (арай чамай гүйх), **чадан ядан орчуулах** (мэдлэг чадвар дутаж арай чамай орчуулах), ...

- 1.6 Утгаа нэг үгийн салбар утгаас үүссэн боловч, эдүгээ хэл зүйн талаар өөр өөрөөр хэлбэржин, үгийн сангийн хувьд бие даасан үгийн үүргээр хэрэглэгдэх үгсийг тус бүрд нь толгой үг болгон бичиж тайлбар, жишээг хавсаргана.

ОД (ОН) I ^{ᠣᠳ} Огторгуйн алсад цэг мэт гэрэлтэн харагдах тэнгэрийн эрхэс: **од түгэх** (харанхуй болж одны харагдах хэмжээ үлэмжхэн нэмэгдэх), ...

ОД II ^{ᠣᠳ} Үхэр, гахай зэрэг амьтны биед орших уут хорхой, цагаан хорхойн авгалдай.

1.7. Нутгийн аялгууны үгийг толгой үг болгохдоо эхлээд монгол хэлний үсгийн дүрмийн дагуу бичээд, ард нь ямар аялгууны үг болохыг тодорхойлж, тухайн үгийн дуудлагыг кирил үсгээр бичиж, ий дараа холбогдох жишээг дагалдуулна.

ЖОРХ [буриад аялгуу] (жорхо) Шагайн сум: **жорх няслах** (шагайн сум няслах) [Г.Гантогтох. “Буриад аялгууны толь”].

II

2.0 Монгол толгой үгийн салбар утгуудыг тус бүрд араб тоогоор дугаарлан бичиж тайлбар жишээг хадаж өгөв.

ТОХЬ I ^{ᠲᠤᠬᠢ} **1.** Тав, тух: **тохь алдах** (тав тухтай байдал алдах), **тав тохь хоришоо** (хүний сэтгэл санаа, бие махбодод ая эвтэй, тааламжтай байдал), **тохь тух хоришоо** (аятай таатай байдал), ... **2.** Байдал төлөв, томоо намба: **тохь муутай** (ажиллаж амьдрах нөхцөл байдал муу), **тохь томоотой хүн** (буурьтай, боловсон хүн), ...

2.1 Үгсийн доторх салаа утгыг байрлуулахдаа эхлээд тэдгээрийн үүсэн буй болсон дарааллыг харгалзан бодтой утгыг нь эхэнд, дараа нь хийсвэр утгыг нь, түүний хойно шилжсэн утгыг нь, сүүлд нь хэлц үгийн дотор орсон утгыг нь дараалуулан байрлуулна.

БУЛАГ I ^{ᠪᠤᠯᠠᠭ} (**1.** Газар доороос ундрэн гарах ус: **2.** *шилжсэн* Эх, үүсвэр: **эрдмийн эх булаг** (эрдмийн эх үүсвэр), **зовлонгийн булаг** (зовлонгийн эх үүсвэр).

2.1.1 Ямар нэг үг нийлэмж үгийн гишүүн болон орсон байвал энэхүү нийлэмж үгийн утгыг нь бүрэн гаргахын үүднээс холбогдох толгой үгийн дотор гүйцэд оруулж тайлбарлана.

ХОНЬ ^{ᠬᠣᠨᠢ} ... **хонин арц** *ургамал* (үнэр сайтай, ширхэг бүдүүн нэг зүйл арц), ...

2.1.2 Утга тодруулах жишээг тухайн үгсийн салбар утгын дараа бичнэ.

ТӨРӨЛ ^{ᠲᠦᠷᠦᠯ} **1.** Хүний амьдрах үе; нэгэн нас: **урьд төрөл** *шашин* (Бурханы шашны ойлголтоор хүнд урьд нас, энэ нас, хойд нас гэж байдаг гэдгийн урьд нас нь, энэ ойлголтоор бол төрөхийн өмнө аливаа хүн, адгуус, хорхой шавж зэрэг амьтан байсан гэх), ... ***төрөл арилжих** (а. Бурханы шашны ёсонд төрлөө солих, хувиран төрөх; б. Үхэх в. Хүний тэс өөр болох **2.** Садан: **төрөл хүмүүс** (садан хүмүүс, гарал угсаа нэгтэй хүмүүс), **төрөл хэл** (гарал, үүсэл нэг буюу ойр хэлнүүд), ... **3.** Анги, зүйл, янз: **аж ахуйн төрөл** (аж ахуйн зүйл), **өөр өөр төрлийн хэмжигдэхүүн** (өөр өөр зүйлийн хэмжигдэхүүн), **төрөл бүрийн** (янз бүрийн), ... **4.** Амьтан, ургамлын язгуур, гарлын ялгавар, зүйл: **төрөл зүйл** *хоришоо* (юмыг адил төстэй шинжээр нь ялгаж ангилсан ангилал), **мигуйн төрөл** (муурын төрөл, мий төрлийн амьтан), **намуу цэцгийн төрөл** (намуу цэцгийн зүйл); **5.** Юмны нэг ижил дүрс, байдал: **төрөл төрлөөр нь ангилах** (юмыг адил шинжээр нь ангилах), **нэг төрөлд багтах** (ижил төсөөрөө нэг ангилалд багтах).

2.1.3 Өвөрмөц хэлц, зүйр цэцэн үг зэргийн утгыг товч тайлбарыг хадан өгсний дараагаар, холбогдох жишээг хадан өгнө. Харин уул өвөрмөц хэлц, зүйр цэцэн үг нь өөр хоорондоо утгын ялгаа бүхий хэд хэдэн утга илэрхийлж байвал хаалтан дотор а. б. в. гэхчлэн үсгээр дугаарлан оруулна. Гэхдээ үгийн утгыг тайлбарлах нь толийн ерөнхий зарчмыг баримтална.

ААВ ^{ᠠᠠᠪ} ... ***аавын цээж** (а. Хаахгар, давлиун зантай хүүхэд буюу залуу б. *яриа* УАЗ маркийн бага оврын ачааны автомашин), ...

- 2.2 Нэг юмны бүрэлдэхүүн хэсгийг уул үгтэй хамтатган холбоо үгээр илэрхийлж байвал гол нэрийг дагалдуулан үүр болгон тайлбарлав. Харин уг зүйлийн төрөлд багтах утгыг нь үүний дараа оруулан утгыг нь тайлбарлан холбогдох жишээг дагалдуулах болно.

ГУТАЛ I ^{ᠭᠤᠲᠠᠯ} Оймсны гадуур, хөлд өмсөх гадуур өмсгөл: **буриад гутал** (зөөлөн дулаан гутал), **монгол гутал** (хоншоор ээтэн, түрийтэй гутал), **савхин гутал** (савхиар хийсэн гутал), **тоохуу гутал** (үхрийн элдсэн арьсан таваг, эсгий оймс, элдсэн суран уяа зэргээс бүрддэг торгууд гутал), **усны гутал** (бороо усанд өмсөх ус нэвтэрдэггүй гутал), **шалбуур гутал** (түүхий арьсыг хөлнөөс хүйс хүргэн бүхлээр нь хийсэн ус гатлахад өмсөх гутал), **эсгий гутал** (эсгийгээр хийсэн гутал), **гутлын омог** (гутлын түрийн дээд ирмэг), **гутлын хамар** (гутлын өмнө үзүүр), **гутлын боом** (зулаг түрий хоёрын уулзвар), **гутлын зуузай** (гутлын өсгийн дотор талд тавих хатуулга), **гутлын зулаг** (монгол гутлын түрий дор залгасан хоёр хажуу), **гутлын эмжээр** (гутлын зулаг, түрийг эмжсэн сарьс), **гутлын боолт** (гутлыг ханзрахаас хамгаалж тусгайлан хийсэн сур), **гутлын өсгий** (гутлын улны хойд хэсэг), **гутлын тос** (гутал өнгөлөх тос), **гутлын тэвчээр** (зулаг ул хоёрын завсар барьж хавчуулсан юм), **гутлын үйлдвэр** (гутал хийх газар), **гутлын хавчаар** (зулаг түрий хоёрын завсар хавчуулсан юм), **гутлын хэвлүүр** (гутал хийхэд хэрэглэх хөлийн хэлбэр бүхий хэлбүүр мод), **гутал хувцас** *хоршоо* (өмсөх хувцас).

III

- 3.0 Монгол хэлний жинхэнэ нэрийг үндсээр нь бичиж оруулав.
- 3.1 Уул жинхэнэ нэр нь харьяалах, өгөх орших, гарахын тийн ялгал болон нийлэмж үгийн бүрэлдэхүүнд орохдоо, мөн олон тооны -уул/-үүд дагавар авахдаа “н”-тэй үндэс шаарддаг үгсийн төгсгөлийн “н”-ийг нь дангаар нь, хэрэв жийрэг эгшиг шаарддаг бол түүнийг нь хамтаар хаалтанд бичиж оруулав.

АЛБА(Н) I ^{ᠠᠯᠪᠠ} 1. Улсын ба албан байгууллагын ажил үйл: ... **албан томилолт** (ажлын газраас өөр газар түр ажиллуулахаар зөвшөөрсөн эрх), **албан тушаал** (албан хаагчийн эрхэлж буй ажлын ерөнхий нэр), **албан хаагч** (аливаа байгууллагын хөдөлмөрийн гэрээний дагуу ажиллаж байгаа ажилтан), **албан байгууллага** (алба ажил эрхлэх газар), **албан бичиг** (алба ажилтай холбоотой бичиг), ...

Хэрэв уул үгийн үндэс нь “н”-тэй бичигдэхдээ өөрчлөгддөг үгсийг өөрчлөгдсөн хэлбэрийг нь хаалтанд оруулан бичив.

СЭЛЭМ (СЭЛМЭН) ^{ᠰᠡᠯᠡᠮ} Байлдаанд хэрэглэх, хурц иртэй, том хутга адил хатгах, цавчих зэвсэг: ... **сэлмэн эвэр** (урагш хандсан, хурц үзүүртэй урт эвэр), **сэлмэн цэцэг** *ургамал* (сэлэм мэт навчтай, улаан буюу улаавтар цэцэгтэй, олон наст ургамал).

Толгой үг болон орсон үндсэн тоо болон хам тооны нэр зарим тохиолдолд “н”-тэй хэрэглэгддэг учир түүнийг нь мөн дээрхийн адил тэмдэглэсэн болно.

АРВАН (АРВАН) ^{ᠠᠷᠪᠠᠨ} **1. ... арван хоног** (арван өдөр, арван шөнө), **арван нэгэн жилийн дунд сургууль** (арван нэгэн жил суралцах дунд сургууль), ... **арван төрөлт** (хөнгөн атлетикийн спортын олон төрөлт), ...
ХОЁУЛИАН ^{ᠬᠣᠡᠭᠦᠯᠢᠠᠨ} Хоёр юмны хамт, цуг

3.1.1. Толгой үг болон орсон нэр үгийг ганц тооны хэлбэрээр бичсэн бөгөөд харин тэмдэг нэр болон зарим нэр үгэнд олон тооны нөхцөл залгахад хам олны утгыг илтгэсэн бол тийм үгийг толгой үг болгон оруулсан болно. Мөн олон тооны нөхцөл нь шинэ үг бүтээх дагаврын үүрэгтэй бол тийм үгсийг толгой үг болгоно.

БАГАЧУУД ^{ᠪᠠᠭᠠᠴᠢᠭᠦᠳᠦ} Бага насны хүүхдүүд, нас бага залуучууд; **сургуулийн багачууд** (сургуулийн сурагчид), **хүүхэд багачууд хориоо** (бага насны хүүхдүүд).

УЛААНТАН ^{ᠤᠯᠠᠠᠨᠲᠠᠨ} хуучирсан Хувьсгалчдыг нэрлэж байсан нэр.

НЯЛХАС ^{ᠨᠢᠶᠯᠬᠢᠰ} **1.** Олон нялх хүүхэд, багачууд: **эх нялхас хориоо** (төрсөн эмэгтэй болон хүүхэд нь); **2. шашин** Хүүхдийн сүнсний хорлол, гээгдсэн хүүхдийн сүнснээс боссон буг.

САЙД ^{ᠰᠠᠶᠢᠳ} Аль нэг яамыг удирдах эрх бүхий засгийн газрын гишүүн: **ерөнхий сайд** (засгийн газрын тэргүүн), **дэд сайд** (орлогч сайд), **орлогч сайд** (засгийн газар, яамны тэргүүн, удирдагч байхгүй үед албан тушаалыг түр хамаарах эрх бүхий албан тушаалтан).

ЭХНЭР ^{ᠡᠬᠡᠨᠡᠷ} **1.** Ураг холбосон эмэгтэй, гэргий: **эхнэр нөхөр хориоо** (гэр бүлийн хүмүүс), **эхнэр хүүхэд хориоо** (нэг гэр бүлийн гишүүдийн ааваас гадна ээж хүүхэд нь).

3.1.2 Зарим үгэнд тийн ялгалын нөхцөл нь үг бүтээх дагаврын үүрэгтэй хэрэглэгддэг бөгөөд, ийм үүрэгтэй нөхцөлийн хойно дахин үг бүтээх дагавар авсан үгсийг толгой үг болгон оруулав.

ӨӨРИЙМСӨГ ^{ᠥᠥᠷᠢᠶᠢᠮᠰᠦᠭ} Өөриймсөх сэтгэлтэй.

ӨӨРИЙНСҮҮ ^{ᠥᠥᠷᠢᠶᠢᠮᠰᠦᠭ} Амархан өөрийн гэсэн сэтгэлтэй болдог.

ХҮНИЙРХҮҮ ^{ᠬᠦᠨᠢᠶᠢᠷᠬᠦᠭᠦ} Өөриймсөг биш зан байдал гаргамтгай: **хүнийрхүү байдалтай** (өөриймсөг биш байдалтай).

3.1.2.1 Тэмдэг нэрийн ард залгаж уул тэмдэг нэрээр илэрсэн шинж сулавтар болохыг заасан -втар, -дуу дагаврын утгыг нарийвчлан үзвэл -втар нь зөвхөн уул шинж сулавтарыг зааж, -дуу нь харин тухайн тэмдэг нэрээр илэрсэн шинжтэй төстэй буюу эсвэл, уул шинжид ойртсон утга илэрхийлдэг тул тайлбарыг ийм маягаар хийж холбогдох жишээг дагалдуулна.

УЛААН ^{ᠤᠯᠠᠠᠨ} **1.** Гал ба цус мэтийн өнгө...

УЛААВТАР ^{ᠤᠯᠠᠠᠪᠲᠠᠷ} Нэлээн улаан, улаан голлосон: **улаавтар туяа** (нэлээн улаан туяа).

УЛААНДУУ ^{ᠤᠯᠠᠠᠨᠳᠤᠭᠤ} Улаан байрын, улаантай ойролцоо.

3.1.3 Үндсэн тооны нэрээс 10⁶⁴ хүртэл тооны орны нэрийг толгой болгон оруулна.

3.1.3.1 Үндсэн тооны нэрийн олон тооны хэлбэрээс гагцхүү үгийн сангийн утга бүхий заримыг нь тольд толгой үг болгон оруулна.

ДӨРВӨД I ^{ᠳᠥᠷᠪᠦᠳ} Монголын нэгэн ястан: **дөрвөдийн хязгаар** (дөрвөд ястны хошуу нутаг).

МЯНГАД ^{ᠮᠢᠶᠨᠭᠠᠳ} Монголын нэгэн аймгийн нэр.

3.1.3.2 Дэс тоо, хам тоо, түгээл тооны нэрээс зөвхөн үлэмжхэн хэрэглэгддэг үгсийг нь тольд оруулна.

АРВААД ^{ᠠᠷᠪᠠᠭᠠᠳ} Арав орчим, арав шахам.

ХОЁРДУГААР ^{ᠬᠣᠡᠷᠲᠤᠭᠠᠭᠠᠷ} Дэс тооны хоёрт тохиолдсон нь.

ХОРИУЛ/АН/ ^{ᠬᠣᠷᠢᠭᠤᠯᠠᠨ} Хорин хүн хамтдаа.

3.1.4 Орон цагийн нэрийг орчин цагийн утга зохиолын хэлэнд хэрэглэгдэх байдлыг харгалзан толгой үг болгон, түүний утгыг тайлбарлана. Иймд түүний гарал үүслийг харгалзсан тайлбар хийгээгүй. Тухайлбал үүгээр гэдэг үг нь энэ хэмээх төлөөний үгийн үйлдэхийн тийн ялгалд байгаа хэлбэр мөн тул үү- гэдгийг нь тусгайлан тайлбарлаагүй, үүгээр гэдгийг нь толгой болгон тайлбарлана.

ҮҮГЭЭР ^{ᠦᠦᠭᠡᠭᠡᠷ} **1.** Энэ хавиар, энүүгээр: **үүгээр түүгээр** *хоришоо* (а. Энэ тэр газраар; б. Энэ тэр юмаар) **2.** Энэ юмаар, энэ байдлаар: **үүгээр бодоход** (энэ байдлаас үзэхэд), **үүгээр үзвэл** (энэ байгаагаар үзвэл).

ТҮҮГЭЭР ^{ᠲᠦᠭᠡᠭᠡᠷ} **1.** Тэр хавиар: **үүгээр түүгээр** *хоришоо* (а. Энэ тэр газраар; б. Энэ тэр юмаар); **2.** Тэр юмаар, тэр байдлаар.

3.1.5 Үйл үгийг үйлт нэрийн ирээдүй цагийн хэлбэрээр бичнэ.

НИСЭХ ^{ᠨᠢᠰᠡᠬ} Жигүүртэн буюу жигүүртэй, далавчтай юмны агаарт халин зорчих: **шувуу нисэх** (шувуу агаарт халин хөөрөх), **онгоц нисэх** (жигүүр бүхий нисэж явдаг унаа халин хөөрөх)

БИЧИХ ^{ᠪᠢᠴᠢᠬ} **1.** Бичиг үсгийг тэмдэглэх: **бичиж авах** (тэмдэглэж авах),...**2.** Зохиож найруулах: **зохиол бичих** (үгээр илэрхийлсэн бүтээл туурвих), ...

3.1.5.1 Үйл үгийн хэв, байдлын дагавар нь үг бүтээх шинж нь илэрхий давамгайлсан тохиолдолд түүнийг нь толгой үг болгон оруулна. Гэхдээ тухайн үйлийн ямар хэв, эсвэл тухайн үйл үгийн ямар байдал болохыг голчлон тайлбарлалгүй, уул үгийн утгыг тайлбарлахад анхааран үзнэ.

БАРИЛДАХ ^{ᠪᠠᠷᠢᠯᠳᠠᠬ} **1.** Ноцолдон хүч тэнхээгээ сорих **2.** Ямарваа юм хоорондоо наалдаж зууралдан салгахад бэрх хэцүү болох: **барилдан наалдах** (зууралдан наалдах), **барилдан хөлдөх** (наалдан хөлдөх), **барилдан шавааралдах** (юмс өөр хоорондоо наалдан шавааралдах); **3.** Ураг бололцох: **ураг барилдах** (ураг бололцох), ...

БАРИЛЦАХ I ^{ᠪᠠᠷᠢᠯᠴᠠᠬ I} **1.** Хамт барих **2.** Харилцан барих; олуул нийлж барих: **барилцаж авах** (бие биеэсээ барьц авах, зууралдах), **гар барилцах** (а. Харилцан гараа атгалцах, мэндлэх; б. *шилжсэн* Эвтэй, найртай байх; эе эвтэй байхаа илэрхийлэх).

БАРИГДАХ I ^{ᠪᠠᠷᠢᠭᠳᠠᠬ I} **1.** Юмыг тэмтрэх үед гарт тааралдах **2.** Гэмт хэрэгт холбогдон эрхээ хасуулан хоригдох; хүний эрхэнд орох; олзлогдох: **сэргийлэхэд баригдах** (цагдаа сэргийлэхэд баривчлагдах, хоригдох), ...

БАРИУЛАХ ^{ᠪᠠᠷᠢᠭᠤᠯᠠᠬ} **1.** Гарт нь атгуулах **2.** Юмыг хийлгэж бүтээлгэх: **байшин бариулах** (байшин барьж босгуулах), **гэр бариулах** (гэр цогцлуулах), ... **3.** Бусдын эрхэнд юмыг үйлдүүлэх; баригдах: **нохойд бариулах** (нохойд зуугдах),...

3.1.5.2 Нэршиж өргөн хэрэглэгддэг үйлт нэрийг толгой үг болгон оруулна.

СУРАГЧ I ^{ᠰᠤᠷᠠᠭᠴᠢ I} Сургуульд суралцаж байгаа хүүхэд: **сурагчийн дэвтэр** (хичээл бичихэд зориулсан дэвтэр), **сурагчийн ширээ** (сургуулийн хүүхдийн хичээл

ном давтах ширээ), **дунд сургуулийн сурагч** (бага сургуулийг төгссөн, ахлах сургуульд ороогүй хүүхэд), ...

ШҮҮХ V ^{ᠰᠢᠭᠦᠬᠡ} Иргэний маргаан, эрүүгийн хэргийг хянан үзэж таслан шийдвэрлэдэг улсын байгууллага: **шүүх хурал** (аливаа гэмт хэргийг байцаан шийтгэх хурал), **шүүх эмнэлэг** (шүүх байгууллагын тусгай эмнэлэг), ...

ЯЛГУУСАН I ^{ᠶ᠋ᠠᠯᠭᠤᠰᠠᠨ} Бүрмөсөн дийлсэн, нэгэнт дийлсэн ялсан нь: **ялгуусан арми** (ялж дийлсэн арми), **ялгуусан хувьсгал** (нэгэнт ялсан хувьсгал), **ялгуусан хэнгэрэг дэлдэх** *хөгжим* (их хэнгэрэг дэлдэх).

3.1.5.3 Нөхцөл үйл үгийн зүйлээс зөвхөн өөр үгсийн айд шилжсэнийг тольд толгой үг болгон оруулна.

БӨГӨӨД ^{ᠪᠥᠭᠦᠳᠡ} Өгүүлбэрийн холбоос үг .

ХҮРТЭЛ ^{ᠬᠦᠷᠲᠡᠯ} Хүрэх болтол: **доороос дээр хүртэл** (доод талаас дээд тал очтол, болтол), **нарийнаас өргөн хүртэл** (нарийнаас өндөр болтол), **одоо хүртэл** (эдүгээ болтол), **орой хүртэл** (орой болтол), ...

ҮЗҮҮЛЭН ^{ᠦᠵᠦᠭᠦᠯᠡᠨ} Багш, заах арга зүйч нарын сургалтандаа үзүүлэхээр зэхсэн зүйл: **үзүүлэн гаргах** (үзүүлж харуулахаар бэлдсэн зүйлээ гаргах).

3.1.6 Төлөөний үгийг ганц тоонд буйг нэрлэхийн тийн ялгалаар, олон тоонд буйг нь харьяалахын тийн ялгалаар, үйл үгийг төлөөлсөн үгийг үйлт нэрийн ирээдүй цагийн хэлбэрээр тус тус хэлбэржүүлэн тольд оруулна.

БИ ^{ᠪᠢ} Нэгдүгээр биеийн ганц тоог төлөөлөн хэлэх үг.

МАНАЙ ^{ᠮᠠᠨᠠᠶ} Нэгдүгээр биеийн олон тоог төлөөлөн хэлэх үг, бидний: **манай ах** (миний ах), **манай гэр** (гэр бүлийнхэнтэйгээ амьдардаг сууц), **манай улс** (бидний улс), **хойноос ирээд хот манайх, хотонд ороод хонь манайх** *зүйр* (давруу зан байдал гаргах гэсэн санаа).

ЯАХ I ^{ᠶ᠋ᠠᠬᠤ} Тухайн үйлийг төлөөлөн хэлж болдог үйлийн асуух төлөөний үг; хэрхэх: **яах аргагүй** (а. зүйг эрж арга олохгүй бэрхшээх, гайхахад хэлэх үг б. Яаж аргалавч үл болох, маргаангүй), **яах вэ** (а. Хэрхвэл зохихыг асуух үг; б. Тоохгүй хэрэгсэхгүй байхад гаргах аялга; в. Аливаа үйлийг тулган шаардахад хэрэглэх үг; г. Боломжийн гэж зөвшөөрөхөд хэрэглэх үг).